



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 19 өдөр

Дугаар 5/13

Бор-Өндөр сум

**Эрдэнэбаатарын Эрдэнэбатыг үүрэгт  
ажлаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Бор-Өндөр Хот Тохижилт” орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын дарга Эрдэнэбаатарын Эрдэнэбат нь ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул 2024 оны 07 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Ажил хүлээн авах, хүлээлгэн өгөх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Х.Галбадрах

Бор-Өндөр сумын Засаг даргын орлогч

Гишүүд:

Э.Түвшинсайхан

ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга

Б.Энхтуяа

“Бор-Өндөр Хот Тохижилт” ОНТҮГ-ын  
Ерөнхий нягтлан бодогч

3. Э.Эрдэнэбатын ажлыг 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдөрт багтаан хүлээлцэж дуусгахыг Комиссын дарга (Х.Галбадрах)-д даалгасугай.

4. Э.Эрдэнэбаттай ээлжийн амралтын болон бусад холбогдох тооцоог хууль тогтоомж, журмын дагуу хийж дуусгахыг “Бор-Өндөр Хот Тохижилт” орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын Ерөнхий нягтлан бодогч (Б.Энхтуяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ